



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/61

Чингис хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.2.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм буурах хүртэл нийт албан хаагчид зайлшгүй шаардлагын улмаас ажил олгогчоос чөлөө авах шаардлага гарсан тохиолдолд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулж, зөвшөөрөл авч байхыг үүрэг болгосугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед албан хаагчид харилцах утсыг 24 цагийн турш нээлттэй байлгаж, удирдлагаас дуудлага ирсэн тохиолдолд шуурхай авч байх, аваагүй тохиолдолд эргэж холбогдох, амралтын өдрүүдэд гадагш явж байгаагаа мэргэжилтнүүд хэлтсийн даргад, хэлтсийн дарга нар Тамгын даргад мэдэгдэж байхыг анхааруулсугай.

3. Тушаалыг албан хаагчдад танилцуулж баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030316